



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 8754

Улаанбаатар хот

**Ой, хээрийн гал түймрээс урьдчилан
сэргийлэх, тэмцэх зарим арга
хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.12 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2026 оны 01, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2026 оны 02, Нийслэлийн Онцгой комиссын даргын 2026 оны 01, Багахангай дүүргийн Онцгой комиссын даргын 2026 оны 01 дүгээр албан даалгавруудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цаг уур, орчны шинжилгээний газраас ирүүлсэн 2026 оны 1 дүгээр улирлын цаг агаарын урьдчилсан мэдээллээр агаарын температур нийт нутгаар олон жилийн дунджаас 2 дугаар сард хүйтэн, 3 дугаар сард дулаан, 4 дүгээр сард дундаж байх ба хаврын улиралд цаг агаарын огцом дулаарал, хүйтрэл үе үе ажиглагдах, агаарын температур ихэнх нутгаар дундаж, хур тунадас нийт нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байгаа буюу хуурайшил, салхи шуурга ихтэй байх магадлал өндөр бөгөөд болзошгүй ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн ногоон бүсэд дагалдах баялгийг ашиглах, аялал, зугаалга, ууланд алхах, төгсөлтийн баярын арга хэмжээ зохион байгуулах болон ил задгай гал гаргахыг 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр, 2026 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд хориглосугай.

2.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор ногоон бүсэд хяналт шалгалт, эргүүл хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх эргүүлийн хуваарийг хоёрдугаар, ногоон бүсэд гарсан гал түймрийн дуудлагаар ажиллах хүн, хүч хэрэгслийн томилгоо, дарааллыг гуравдугаар, ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр зохион байгуулах ажлын төлөвлөгөөг дөрөвдүгээр, үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн төсвийг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Дүүргийн ногоон бүсэд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахад шаардагдах 1,833,700 (Нэг сая найман зуун гучин гурван мянга долоон зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийсэн ажил, үр дүнг танилцуулах, эргүүл, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, нэгдсэн бодлого, удирдлагаар хангаж ажиллахын Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах)-т үүрэг болгосугай.


5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны ⁰⁴ дугаар сарын ⁰¹ –ны өдрийн
^{8/5.1} дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЭРГҮҮЛ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн

ахлагч:

Б.Цогбадрах

Онцгой байдлын

хэлтсийн дарга, хурандаа

Гишүүд:

Г.Дагвадорж

Дүүргийн менежер

Л.Санжийжамц

Засаг даргын Тамгын газрын
дарга

Д.Хүрэлбаатар

Хотын стандарт, тохижилт,
нийтийн аж ахуйн хэлтсийн
дарга

Т.Лхагвасүрэн

Цагдаагийн хэлтсийн дарга,
хурандаа

Н.Нямзав

1-р хорооны Засаг дарга

Б.Батзориг

2-р хорооны Засаг дарга

Д.Шүрэн-Эрдэнэ

Мал эмнэлгийн тасгийн улсын
байцаагч

С.Азбаяр

Төмөр замын Багахангай
өртөөний дарга

Нарийн бичгийн дарга:

М.Мөнхболд

Гал түймрийн Улсын

хяналтын байцаагч, ахмад

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 09-ны өдрийн
А/Б/У дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЭРГҮҮЛИЙН ХУВААРЬ

№	Зохион байгуулах байгууллага, албан тушаалтан	Хяналт, шалгалтад оролцох бүрэлдэхүүн	Ажиллах чиглэл	Шалгалт хийх хугацаа
Хаврын хуурайшилтын үе 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 10				
1	Онцгой байдлын хэлтэс Хурандаа Б.Цогбадрах	Дүүргийн менежер, ГТУХ-ын байцаагч	Хээхрийн хоолой, Үнэгтэй, Хуурайн худаг, Бөөгийн толгой, Өндөр дэл, Гэр овоо, Хангайн хөндий, Магнайн бууц, Гурван толгой, Алтгана овоо	04-р сарын 01-ний өдрөөс 04-р сарын 14
2	Онцгой байдлын хэлтэс Хурандаа Б.Цогбадрах	ЗДТГ-ын дарга, ГТУХ-ын байцаагч		04-р сарын 15-ны өдрөөс 04-р сарын 28
3	Онцгой байдлын хэлтэс Хурандаа Б.Цогбадрах	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, ГТУХ-ын байцаагч		04-р сарын 29-ний өдрөөс 05-р сарын 12
4	Онцгой байдлын хэлтэс Хурандаа Б.Цогбадрах	Цагдаагийн хэлтэс, ГТУХ-ын байцаагч		05-р сарын 13-ны өдрөөс 05-р сарын 26
5	Онцгой байдлын хэлтэс Хурандаа Б.Цогбадрах	1 дүгээр хороо, ГТУХ-ын байцаагч		05-р сарын 27-ны өдрөөс 06-р сарын 10
Намрын хуурайшилтын үе 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10				
1	Онцгой байдлын хэлтэс Хурандаа Б.Цогбадрах	1, 2 дугаар хороо, ГТУХ-ын байцаагч	Хээхрийн хоолой, Үнэгтэй, Хуурайн худаг, Бөөгийн толгой, Өндөр дэл, Гэр овоо, Хангайн хөндий, Магнайн бууц, Гурван толгой, Алтгана овоо	09-р сарын 20-ны өдрөөс 10-р сарын 03
2	Онцгой байдлын хэлтэс Хурандаа Б.Цогбадрах	2 дугаар хороо, ГТУХ-ын байцаагч		10-р сарын 04-ний өдрөөс 10-р сарын 17
3	Онцгой байдлын хэлтэс Хурандаа Б.Цогбадрах	Мал эмнэлгийн тасаг, ГТУХ-ын байцаагч		10-р сарын 18-ны өдрөөс 10-р сарын 31
4	Онцгой байдлын хэлтэс Хурандаа Б.Цогбадрах	Багахангай өртөө, ГТУХ-ын байцаагч		11-р сарын 01-ний өдрөөс 11-р сарын 10

Тайлбар: Хяналт, шалгалтын хэсгүүд нь эргүүл, хяналт шалгалтыг 14 хоногт 1 удаа зохион байгуулж эргүүл, хяналт шалгалтаар ажилласан тухай дүнг 14 хоног тутамд дүүргийн Онцгой байдлын хэлтэст ирүүлнэ.




Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 01 -ны өдрийн
АБС дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

НОГООН БҮСЭД ГАРСАН ГАЛ ТҮЙМРИЙН ДУУДЛАГААР АЖИЛЛАХ
ХҮН, ХҮЧ ХЭРЭГСЛИЙН ТОМИЛГОО, ДАРААЛАЛ

№	Байгууллагын нэр	Хүний тоо	Автомашин марк, дугаар	Түймрийн багаж, хэрэгсэл							Хариуцах албан тушаалтан, утасны дугаар	
				Байршил тогтоогч GPS	Үлээгч аппарат	Үүргийн гал унраагуур /РЛО/	Савар	Тросон шүүр	Гөвүүр	Хүрз		Усны сав 20-30л
1	Онцгой байдлын хэлтэс 1 дүгээр бүлэг	5	УАЗ-Фургон 62-60 УБЧ	1	2	3	2	3	3	3	5	х/ч Г.Отгонбаатар 89011853
2	Онцгой байдлын хэлтэс 2 дугаар бүлэг	5	Ланд круйзер 78 11-59 УЕУ	-	2	3	2	3	3	3	5	а/х М.Мөнхболд 96008619
3	Цагдаагийн хэлтэс	6	Renault Duster 13-54 УАМ	1	-	-	-	3	3	3	5	а/д Р.Баярсүрэн 88990116
4	“Илч-Орд” ОНӨААТҮГ	10	Өөрөө буулгагч 15-89 УАН, Ковш 98-63 УР	-	-	-	-	2	10	5	3	Ерөнхий инженер Х.Сансрайдорж 88544093
5	Багахангай тохижилт ОНӨААТҮГ	9	HYUNDA STARIX 81-92 УНЧ Bongo 34-61 УБН	-	2	-	5	4	5	10	2	Инженер Г.Отгончулуун 89177918
6	Ус суваг ашиглалтын товчоо	6	Бонго 41-79 УНТ Фотон-Усны 03-62 УЕЕ	-	-	-	5	3	3	3	2	Т.Ганбаяр 99662436
7	Гэрэлтүүлэг ногоон байгууламж ОНӨААТҮГ	8	Альфард 64-92 УНВ, Усны 10тн 12-91 УАН	-	-	-	2	2	2	2	2	Инженер Л.Бадрах 88047892
8	Засаг даргын Тамгын газар	10	TOYOTA Hiace 20-07 УБЯ	-	-	-	-	5	2	3	-	Нярав П.Дэлгэр 880333627
9	Замын 17 дугаар хэсэг	10	Уаз-Фургон 16-65 УНН	-	2	-	-	3	4	1	-	Ч.Цоггэрэл 86111871

10	Багахангай дүүргийн 1 дүгээр хороо	7	-	-	-	-	-	-	1	2	3	3	-	Л.Оюунчимэг 99981705
11	Багахангай дүүргийн 2 дугаар хороо	6	-	-	-	-	-	-	2	2	2	2	1	Б.Батзориг 99105204
12	БЗАУ-ний анги	9	Бонго 72-22 УБЯ	-	-	-	-	-	1	2	3	4	-	М.Даваадорж 95116839
13	Багахангай өртөө	6	-	-	-	-	-	-	-	2	8	5	4	С.Азбаяр 86114157
14	Биеийн тамир спортын хороо	8	Корала,18-83УНХ П-20, 13-51 УЕК	-	-	-	-	-	1	3	4	5	6	Д.Алтанхуяг 88503670
15	91 дүгээр ургууль	8	Hyundai County 78-36 УНС	-	-	-	-	-	1	2	2	4	2	Ж.Насанжаргал 99791927
16	94 дүгээр сургууль	5	-	-	-	-	-	-	1	1	1	1	1	Нярав Д.Туяа 80740217
17	ХХҮХ	5	-	-	-	-	-	-	-	2	2	4	2	Б.Мөнгөнтуяа 94089202
18	44 дүгээр цэцэрлэг	5	-	-	-	-	-	-	-	1	2	2	2	О.Машбат 85113904
19	ХГБХХ хэлтэс	2	-	-	-	-	-	-	-	-	-	3	2	А.Анхбаяр 88661861
Нийт		130	17	3	8	6	23	45	62	65	44	19		




Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн
08/09 дугаар захирамжийн дөрөвдүгээр хавсралт

ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ
ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зохин байгуулах арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Хамтран ажиллах байгууллага, хуулийн этгээд	Хяналт тавих албан тушаалтан
1	Хил залгаа сумдын Засаг даргатай Ой, хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, харилцан ажиллах төлөвлөгөө боловсруулан батлуулан хэрэгжилтийг хангах.	4 дүгээр сард	ГТУХ-ын байцаагч, а/х М.Мөнхболд	Хил залгаа сумдын Засаг дарга нар	ОБХ-ийн дарга, хурандаа Б.Цогбадрах
2	Ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн барилга байгууламжид хяналт шалгалт зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах.	5, 9 дүгээр саруудад	ГТУХ-ын байцаагч, а/х М.Мөнхболд	-	ОБХ-ийн дарга, хурандаа Б.Цогбадрах
3	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хөдөлгөөнт эргүүлийн үйл ажиллагаа зохион байгуулж, түймэр гарсан үед хүн хүч, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах.	Хуваарийн дагуу тухай бүр	ГТУХ-ын байцаагч, а/х М.Мөнхболд	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	ОБХ-ийн дарга, хурандаа Б.Цогбадрах
4	Дүүргийн ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон хороодод ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх "Дүүргийн Засаг даргын нэрэмжит" үзлэг зохион байгуулах.	9 дүгээр сард	ГТУХ-ын байцаагч, а/х М.Мөнхболд	ЗДТГ, Онцгой байдлын хэлтэс	ОБХ-ийн дарга, хурандаа Б.Цогбадрах
5	Онцгой байдлын хэлтсийн ой, хээрийн түймэр унтраах автомашин техник, багаж хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах чиглэлээр үзлэг, шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулах.	4 дүгээр сарын 10-ны дотор	ГТУХ-ын байцаагч, а/х М.Мөнхболд	Онцгой байдлын хэлтэс	ОБХ-ийн дарга, хурандаа Б.Цогбадрах
6	Аж ахуйн нэгж, байгууллагуудаар ой, хээрийн түймэр унтраах анхан шатны багаж зэвсэглэмж (Тросон шүүр, гөвүүр, савар, хүрз, усны сав) зэргийг стандартын дагуу бэлтгүүлэн Онцгой байдлын хэлтэст төвлөрүүлэх.	4 дүгээр сарын 20-ны дотор	ГТУХ-ын байцаагч, а/х М.Мөнхболд	1, 2 дугаар хорооны ажлын алба	ОБХ-ийн дарга, хурандаа Б.Цогбадрах
7	Ой, хээрийн түймэр гарсан шалтгаан нөхцөлийг тогтоон, эзэн холбогдогчийг шуурхай илрүүлж, гэм	Тухай бүр	ГТУХ-ын байцаагч, а/х М.Мөнхболд	Цагдаагийн хэлтэс, Хороод	ОБХ-ийн дарга, хурандаа Б.Цогбадрах

	буруутай этгээдэд хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэж ажиллах.				Б.Цогбадрах
8	Ой, хээрийн түймэр унтраахад дайчлах гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн үйл ажиллагаа сайжруулах, тэдгээрийг ой, хээрийн гал түймрийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвар эзэмшүүлэх зорилгоор сургалт зохион байгуулж чадавхжуулах.	5-р сард	ГТУХ-ын байцаагч, а/х М.Мөнхболд	ОБХ-ийн ББСХМ мэргэжилтэн	ОБХ-ийн дарга, хурандаа Б.Цогбадрах
9	Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, вэб сайт, байгууллагын пэйж хуудсуудаар дамжуулан иргэд олон нийтэд мэдээлэх.	Тухай бүр	ГТУХ-ын байцаагч, а/х М.Мөнхболд	ОБХ-ийн ББСХМ мэргэжилтэн	ОБХ-ийн дарга, хурандаа Б.Цогбадрах

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 01-ны өдрийн
04 дугаар захирамжийн тавдугаар хавсралт



ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, сурталчилгаа, бэлэн байдлыг хангах ажилд шаардагдах зардал

№	Материалын нэр		Хэмжих нэгж (ш)	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Масс мессежээр сэрэмжлүүлэг хүргэх		12	20,000	240,000
2	Засаг даргын нэрэмжит үзлэг	Анонс	6м ²	26,000	156,000
		Бензин	30л	2610	78,300
		Дизель түлш	20л	3470	69,400
3	Урьдчилан сэргийлэх самбар, анонс бэлтгэх	Анонс	14м ²	26,000	364,000
		Квадрат төмөр	24м	9,000	216,000
		Лист төмөр	8ш	80,000	640,000
		Тасдагчийн ир	1 хайрцаг	10,000	10,000
		Шрүп (төмрийн)	2 хайрцаг	30,000	60,000
Нийт					1,833,700